		Ажлын хувцас /өвөл/	6-9-17 6-9-18	хос	1	2
		Ажлын бээлий	6-5-17	хос	6	1
3	Уурын зуухны галч	Ноосон цамц (сүлжмэл)	3-9	хос	1	1
		Ажлын хувцас /өвөл/	6-9-17 6-9-18	хос	1	1
		Ажлын бээлий	6-5-17	хос	6	1
		Ажлын гутал /өвөл/	6-9-21	хос	1	1
4	Сантехникийн механик, слесарь	Ноосон цамц (сүлжмэл)	3-9	хос	1	1
		Ажлын хувцас /зун/	6-9-15 6-9-16	хос	1	1
		Ажлын хувцас /өвөл/	6-9-17 6-9-18	хос	1	2
		Ажлын бээлий	6-5-17	хос	6	1
		Ажлын гутал /зун/	6-9-20	хос	1	1
5	Үйлчлэгч	Даавуун халад, малгай	6-9-10 6-9-11	хос	2	1
		Резинэн бээлий	6-9-8	хос	12	1
6	Номын санч	Даавуун халад	6-9-11	хос	1	2
7	Халуун усны эрхлэгч	Даавуун халад	6-9-11	хос	2	1
		Углааш	6-9-13	хос	1	1
8	Халуун усны угаагч	Даавуу халад, малгай	6-9-10 6-9-11	хос	2	1
		Углааш	6-9-13	хос	1	1
		Хулдаасан хормогч	6-9-6	хос	1	1
		Резинэн бээлий	6-9-8	хос	12	1
9	Халуун усны механикч	Даавуу халад, малгай	6-9-10 6-9-11	хос	1	1

	ИПДАУУАЭГЭН	Углааш	6-9-13	хос	1	1
10	Нярав, эд хариуцагч, түгээгч	Ажлын хувцас /зун/	6-9-15 6-9-16	хос	2	1
		Ажлын хувцас /өвөл/	6-9-17 6-9-18	хос	1	2
		Ноосон цамц (сүлжмэл)	3-9	хос	1	2
		Ажлын бээлий	6-5-17	хос	2	1
		Резинэн хормогч /шатахуун/		хос	1	1
11	Цахилгаанчин	Ажлын хувцас /зун/	6-9-15 6-9-16	хос	1	1
		Ажлын бээлий	6-5-17	хос	6	1
		Усны гутал	6-9-22	хос	1	1
12	Гагнуурчин	Ажлын хувцас /зун/	6-9-15 6-9-16	хос	1	1
		Брезентэн бээлий	6-9-19	хос	6	1
		Ажлын гутал /зун/	6-9-20	хос	1	1
		Дуулга	6-9-14	ш	1	2
13	Барилгын талбайн инженер, техникч	Ажлын хувцас /зун/	6-9-15 6-9-16	хос	1	1
		Ажлын гутал /зун/	6-9-20	хос	2	1
		Дуулга	6-9-14	ш	1	2
14	Барилгын засал чимэглэлчин, өрлөгчин, угсрагч	Ажлын хувцас /зун/	6-9-15 6-9-16	хос	1	1
		Ноосон цамц (сүлжмэл)	3-9	хос	1	1
		Ажлын бээлий	6-5-17	хос	4	1
		Ажлын гутал /зун/	6-9-20	хос	2	1
		Ажлын өвлийн гутал	6-9-21	хос	1	1
Дуулга	6-9-14	ш	1	2		
15	Агуулахын ачигч, хүнсний нярав, түгээгч	Ажлын хувцас /зун/	6-9-15 6-9-16	хос	1	1
		Ажлын хувцас /өвөл/	6-9-17 6-9-18	хос	1	1
		Ажлын бээлий	6-5-17	хос	4	1
		Ажлын гутал /зун/	6-9-20	хос	1	1
		Ажлын өвлийн гутал	6-9-21	хос	1	2
16	Гал тогооны тасгийн дарга, ахлах тогооч	Даавуун халад, малгай, цамц, өмд, хормогч	6-9-1 6-9-3 6-9-4 6-9-11	хос	1	1
		Гар, нүүрийн алчуур	6-9-12	хос	4	1
		Ажлын гутал	6-9-9			
		Углааш	6-9-13	хос	1	1
17	Ээлжийн тогооч	Даавуун халад, малгай, цамц, өмд	6-9-2 6-9-3 6-9-4 6-9-11	хос	1	1
		Цээживчтэй хормогч	6-9-7	ш	1	1
		Ажлын гутал	6-9-9			
		Углааш	6-9-13	хос	1	1
		Гар, нүүрийн алчуур	6-9-12	хос	4	1
18	Бэлтгэгч, сав хэрэглэл угаагч	Даавуун малгай, цамц, өмд	6-9-10 6-9-3 6-9-4	хос	1	1
		Хулдаасан хормогч	6-9-6	ш	1	1

		Ажлын гутал	6-9-9			
		Резинэн бээлий	6-9-8	хос	12	1
19	Гал тогооны жижүүр	Даавуун нөмрөг	6-9-5	хос	2	1
20	Гал тогооны ажлыг шалган зааварлагч	Даавуун нөмрөг	6-9-5	ш	3	1
21	Талхан цехийн эрхлэгч	Даавуу халад, малгай	6-9-10 6-9-11	хос	1	1
22	Талх баригч	Богино ханцуйтай даавуун цамц, өмд, малгай	6-9-3 6-9-4 6-9-10	хос	1	1
		Ажлын гутал	6-9-9			
		Углав	6-9-13	хос	1	1
		Гар, нүүрийн алчуур	6-9-12	хос	4	1
		Брезентэн бээлий	6-9-19		2	1
23	Талх тээврийн тусгай машины нярав жолооч, няраа, махны түгээгч, ачигч	Даавуу халад, малгай	6-9-10 6-9-11	хос	2	1
		Ажлын бээлий	6-5-17	хос	6	1
		Цээжмөчтэй хормогч	6-9-7	хос	2	1
		Дэгтий	6-7-3	хос	2	1
24	Авто болон төмөр замын бүрэлдэхүүн	Ажлын хувцас /зун/	6-9-15 6-9-16	хос	1	1
		Ажлын хувцас /өвөл/	6-9-17 6-9-18	хос	1	1
		Ажлын бээлий	6-5-17	хос	4	1
		Ажлын гутал	6-9-20	хос	1	1
		Ажлын өвлийн гутал	6-9-21	хос	1	2

Тайлбар:

Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн алба хаагчид Төрийн болон цэргийн ёслолын тоглолтын китель, өмд /ёслолын/ авсан тохиолдолд ёслолын хувцас, хэрэглэлээр хангагдахгүй.

Хангалтын төв болон бүсийн баазуудын нярав, засварчин, нэгтгэл, ангиудын инженер техникийн засварчин, аккумуляторчин, нярав албан тушаалын ЦАХ-дад олгож болно.

* Тэмдэглэгээтэй хувцас, хамгаалах хэрэглэлийг цэргийн алба хаагчдад алба хаах хугацаанд түр олгож, хураан авна.

**ХОЁР. ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН СОНСОГЧИЙН
ХУВЦАС, ХЭРЭГЛЭЛИЙН НОРМ**

Д/д	Хувцас, хэрэглэлийн нэр	Загварын код	Хэмжих нэгж	Тоо	Эдлэх хугацаа (жил)
1	2	3	4	5	6
1	Албаны майхан малгай	7-1	ш	1	4
2	Бүрх малгай	7-2	ш	1	4
3	Майхан малгай	7-3	ш	1	4
4	Өвлийн малгай	2-14б	ш	1	4
5	Албаны китель, өмд, юбка /мөрддэстэй, цэргийн байгууллагын болон анги байгууллагын таних тэмдэгтэй/	7-5, 7-6, 7-13	хос	1	4
6	Хавар намрын пальто	7-7	ш	1	4
7	Албаны дулаан хүрэм /мөрддэстэй, цэргийн байгууллагын болон анги байгууллагын таних тэмдэгтэй/	7-8	ш	1	4
8	Албаны цамц урт ханцуйтай /цэнхэр/	7-9	ш	1	4
9	Албаны цамц богино ханцуйтай /цэнхэр/	7-10	ш	1	4
10	Ёслолын цамц	7-11	ш	1	4
11	Гурвалжин захтай цамц (нэхмэл)	7-12	ш	1	4
12	Албаны зангиа	7-14а, 7-14б	ш	1	4
13	Хүзүүний ороолт (сүлжмэл)	7-15	ш	1	4
14	Савхин бээлий	7-16	хос	1	4
15	Ёслолын бээлий	7-17	хос	1	4
16	Өмдний тэлээ	7-18	ш	1	4
17	Зуны албаны гутал	7-19а, 7-19б	хос	1	4
18	Өвлийн албаны гутал	7-20а, 7-20б	хос	1	4
19	Саан зүүлт	7-21	ш	1	4
20	Саан бүс	7-22	ш	1	4
21	Малгайн тэмдэг	7-23	ш	2	1 удаа
22	Захны таних тэмдэг	7-24	хос	2	4
23	Нэрийн тэмдэг	7-25	ш	1	4
24	ЦНС тэмдэг /хатгамал/	7-26	ш	1	4
25	Цолны тэмдэг	7-27	ш		Цол авахад
26	Албаны хатуулгатай мөрддэс	7-28	хос	2	4
27	Байгууллагын ялгах тэмдэг	7-29	ш	1	4
28	ЦНС-ийн ханцуйн ялгах тэмдэг	7-30	ш	1	4
29	Хээрийн малгай	2-33	ш	1	4
30	Ноосон малгай, хоолойвч	2-34	хос	1	4

31	Хээрийн китель, өмд (эрэгтэй)	2-35, 2-36	хос	1	4
32	Хээрийн китель, өмд (эмэгтэй)	2-37, 2-38	хос	1	4
33	Өвлийн хээрийн хүрэм, өмд (эрэгтэй)	2-46а	ш	1	4
34		2-46б	ш	1	4
35	Өвлийн хээрийн хүрэм, өмд (эмэгтэй)	2-47а	ш	1	4
36		2-47б	ш	1	4
37	Ноосон цамц /мөрдөстэй/	2-23	ш	1	4
38	Хээрийн богино ханцуйтай цамц /захгүй/	2-43	ш	1	4
39	Хээрийн дулаан цамц	2-44	ш	1	4
40	Ноосон оймс		хос	1	1
41	Даавуун оймс		хос	2	1
42	Зуны хагас түрийтэй хар гутал	3-13	хос	1	4
43	Өвлийн хагас түрийтэй хар гутал	3-14	хос	1	4
44	Тактикийн бүс	2-48	ш	1	1 удаа

Тайлбар: Суралцах хугацаандаа хангалтаар авсан хувцас хэрэглэлийн эдэлгээний хугацаа дуусаагүй бол офицер, ахлагчийн албанд шилжин ажиллахад нь үргэлжлүүлэн тооцно.

**ГУРАВ. ЦЭРГИЙН ДАЙЧИЛГААТАЙ СУРГУУЛЬ, ЦУГЛАРАЛТАД ОРОЛЦОЖ
БАЙГАА БЭЛТГЭЛ ҮҮРЭГТЭН БОЛОН ОЮУТАН ЦЭРГИЙН ХУВЦАС, АХУЙН
ХЭРЭГЛЭЛИЙН НОРМ**

д/д	Хувцас, хэрэглэлийн нэр	Загварын код	Хэмжих нэгж	Тоо	Эдлэх хугацаа /жил/
Нэг. Балтгэл офицер, ахлагч					
1	Хээрийн малгай	2-33	ш	1	2
2	Ноосон малгай, хоолойвч	2-34	ш	1	2
3	Хээрийн китель, өмд (эрэгтэй)	2-35, 2-36	ш	1	2
4	Хээрийн китель, өмд (эмэгтэй)	2-37, 2-38	хос	1	2
5	Футболк (бор шар)	2-43	ш	1	1 удаа
6	Хээрийн дулаан цамц	2-44	ш	1	3
7	Хээрийн хүрэм, өмд	2-39, 2-40	хос	1	4
8		2-41, 2-42	хос	1	4
9	Өвлийн хээрийн хүрэм, өмд	2-46а, 2-46б	хос	1	4
10		2-47а, 2-47б	хос	1	4
11	Хээрийн гутал	2-52а	хос	1	3
12		2-52б	хос	1	3
13	Хээрийн мөрдэс	4-2-19	хос	2	1 удаа
Хоёр. Балтгал байлдагч					
1	Хээрийн малгай	3-1	ш	1	2
2	Ноосон малгай, хоолойвч	3-3	хос	1	2
3	Хээрийн китель, өмд (эрэгтэй)	3-4, 3-5	хос	1	2
4	Хээрийн өвлийн хүрэм	3-6	ш	1	3
5	Дотортой китель, өмд	3-7, 3-8	хос	1	3
6	Ноосон цамц (сүлжмэл)	3-9	ш	1	2
7	Нөмрөг цув	3-10	ш	1	6
8	Өмдний тэлээ	3-11	ш	1	3
9	Тактикийн бүс	3-12	ш	1	5
10	Зуны гутал	3-13	хос	1	3
11	Өвлийн гутал	3-14	хос	1	3
12	Хээрийн мөрдэс	4-3-2	хос	2	1 удаа
Гурав. Оюутан цэрэг					
1	Хээрийн малгай	3-1	ш	1	2
2	Хээрийн китель, өмд	3-4, 3-5	хос	1	2
3	Ноосон цамц (сүлжмэл)	3-9	ш	1	2
4	Нөмрөг цув	3-10	ш	1	6
5	Өмдний тэлээ	3-11	ш	1	3
6	Тактикийн бүс	3-12	ш	1	5
7	Зуны гутал	3-13	хос	1	2
8	Дотуур цамц (мөйк)	6-8-3	ш	2	1
9	Дотуур богино өмд (трусy)	6-8-4	ш	4	1
10	Нимгэн оймс	6-8-6	хос	6	1
Дөрөв. Бусад болон ахуйн хэрэглэл					

1	Ванны алчуур		ш	1	1 удаа
2	Гарын алчуур		ш	1	1 удаа
3	Хамрын алчуур		хос	2	6 сар
4	Дэр		хос	1	5
5	Дулаан хөнжил		ш	1	5
6	Гудас /матрас/		ш	1	5
7	Орны бүтээлэг		ш	1	5
8	Орны цагаан хэрэглэл		ш	1	1
9	Гарын саван 75 гр		ш	3	сар бүр
10	Шингэн саван /500 гр/		ш	1	сар бүр
11	Шампунь /5 мл/		ш	1	7 хоног
12	Биеийн үнэр дарагч /100 мл/		ш	1	6 сар
13	Шүдний сойз		ш	1	улирал бүр
14	Шүдний оо /120 гр/		ш	1	сар бүр
15	Углааш		хос	1	1
16	Сахлын татуурга /нэг удаагийн/		ш	2	сар бүр
17	Гутлын тос /40 гр/			1	сар бүр

Тайлбар:

а. 3 сараас дээш хугацаагаар түр цугларалтад оролцож байгаа бэлтгэл үүрэгтнийг шинэ хувцсаар, 3 сараас доош хугацаатай байвал 2, 3 дугаар зэргийн хувцас хэрэглэлээр хангана.

б. Түр цугларалтад оролцож байгаа бэлтгэл офицерт албан тушаалын цолны тэмдэгтэй мөрдэс олгоно.

в. Дээрх хувцас, хэрэглэлийн эдэлгээний хугацааг эдэлсэн хугацаагаар тооцно.

**ДӨРӨВ. ЦЭРГИЙН ГЭРЭЭТ БОЛОН ХУГАЦААТ ЦЭРГИЙН АЛБА ХААГЧ,
ЦЭРГИЙН СУРГУУЛИЙН СОНСОГЧИЙН АЖЛЫН ХУВЦАС, АХУЙН
ХЭРЭГЛЭЛИЙН НОРМ**

д/д	Ахуйн хэрэглэлийн нэр	Загварын код	Хэмжих нэгж	Тоо	Эдлэх хугацаа /жил/
1. Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч, цэргийн сургуулийн сонсогчийн ахуйн хэрэглэлийн норм					
1	Гар, нүүрийн алчуур		Ш	2	1
2	Хамрын алчуур		Ш	4	1
3	Захны даавуу /48*8см/		Ш	6	1
4	Ванны алчуур		Ш	1	1
5	Гарын саван 75 гр /усанд ороход 2ш/		Ш	4	сар бүр
6	Шингэн саван /500 гр/		Ш	1	улирал бүр
7	Шампунь /5 мл/		Ш	2	7 хоног
8	Биений үнэр дарагч /100 мл/		Ш	2	6 сар
9	Шүдний сойз		Ш	1	улирал бүр
10	Шүдний оо /120 гр/		Ш	12	1
11	Зүү		Ш	2	1
12	Оёдлын утас /200 м/		Ш	2	1
13	Углааш		хос	1	1
14	Сахлын татуурга /нэг удаагийн/		Ш	24	1
15	Гутлын тос /40 гр/		Ш	4	улирал бүр
16	Цагаан хэрэглэл		ком	2	1
17	Дулаан хөнжил		Ш	1	5
18	Гудас /матрас/		Ш	1	5
19	Дэр		Ш	1	5
20	Орны бүтээлэг		Ш	1	5
21	* Нүүрний крем		Ш	1	1
22	* Чийгшүүлэгч		Ш	1	1
23	* Үнэртэй ус		Ш	1	1
24	* Уруул өнгөлөгч		Ш	1	1
2. Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн ажлын хувцас, хэрэглэлийн норм					
2.1. Хугацаат цэргийн алба хаагч					
1	Ажлын хувцас /зун/	6-9-15 6-9-16	хос	1	1
2.2. Барилга, инженерийн ангийн цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч					
1	Ажлын хувцас /зун/	6-9-15 6-9-16	хос	2	1
2	Ажлын хувцас /өвөл/	6-9-17 6-9-18	хос	1	1
3	Ажлын бээлий	6-5-17	хос	6	1
4	Ажлын гутал /өвөл/	6-9-21	хос	1	2
5	Каск /ажлын/	6-9-14	ш	1	2
2.3. Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагч /Малчин/					

1	Саравчтай малгай		ш	1	1
2	Нэхий дээл		ш	1	3
3	Нэхий бээлий		хос	1	1
4	Дулаан дотортой дээл		ш	1	2
5	Дан дээл		ш	1	1
6	Дулаан дотортой өмд		ш	1	1
7	Ажлын гутал /өвөл/	6-9-21	хос	1	1
8	Ханцуйвч /төлчдөд/		хос	1	1
9	Даавуу халад, малгай /саальчдад/	6-9-10 6-9-11	ш	1	1

Тайлбар:

* Тэмдэглэгээтэй ахуйн хэрэглэлийг зөвхөн төрийн болон цэргийн ёслолын хүндэт харуул, торгон цэрэг (морьт) хамрагдана.

ТАВ. ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭД ХОГШЛЫН ЭДЭЛГЭЭНИЙ НОРМ

д/д	Материал, хэрэгслийн нэр	Хэмжих нэгж	Тоо	Эдлэх хугацаа /жил/
1. Цэргийн алба хаагчийн ашигладаг тоног төхөөрөмж, эд хогшлын эдэлгээний хугацаа, норм				
1	Оёдлын машин /гар, хөл, цахилгаан/	ш	1	8
2	Тооны машин	ш	1	3
3	Цахилгаан индүү /суурьтай/	ш	1	3
4	Уурын индүү	ш	1	3
5	Гутлын сойз	ш	1	0.5
6	Хувцасны сойз	ш	1	2
7	Үсний цахилгаан машин	ш	1	2
8	Үсний гар машин	ш	1	3
9	Гутлын засварын багаж	ком	1	6
10	Үсчний хайч	ш	1	5
11	Толь	ш	1	10
12	Үсчний багаж	ком	1	5
13	Хагас автомат угаалгын машин	ш	1	8
14	Бүрэн автомат угаалгын машин	ш	1	8
15	Оёдлын тэвнэ	ш	1	1
16	Оёдлын гар зүү	ш	4	1
17	Оёдлын утас /№30,40/	ш	200	1
18	Үүргэвч /аранз/	ш	1	4
19	Дашмагны уут	ш	1	6
20	Дашмаг	ш	1	10
21	Аяны тогоо	ш	1	10
22	Сахлын машин /цахилгаан/	ш	1	2
23	Сахлын машин /механик/	ш	1	3
2. Морьт цэргийн тоног төхөөрөмж болон цэргийн асар, палатка, майхан хэрэглэлийн норм				
1	Карказтай майхан	ком	1	5
3	УСТ-56	ком	1	8
4	УСБ-56	ком	1	8
5	Асар палатканы мод	ш	1	8
6	Аргамж, татлагын тос олс /25м/	ш	1	1
7	Цэрэг эмээл	ш	1	4
8	Хазаар	ш	1	2
9	Ногт	ш	2	1
10	Тэмээний ногт	ш	1	1
11	Чөдөр	ш	2	1
12	Богц	ш	1	5
13	Суран ташуур	ш	1	3
14	Тохош	ш	1	3
15	Тэмээний буйл /товх, бурантаг уут, гэрний хамт/	ш	2	1
16	Хивсэн тохош	ш	1	8

ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН ХУВЦАС ХЭРЭГЛЭЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигт тусгагдаагүй цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдын дотуур хувцас, ахуйн хэрэглэл, үйлчилгээний ажилтан, алба хаагчдын хөдөлмөр хамгаалал болон тусгай зориулалтын хувцас хэрэглэлийн загварын тайлбар.

Тусгай зориулалтын хувцас хэрэглэлийг дараах байдлаар тодорхойлсон.

Үүнд:

- 1.1 Цэргийн алба хаагчийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэл.
- 1.2 Тусгай хүчний цэргийн алба хаагчийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэл.
- 1.3 Нисгэгч, нисэхийн инженер, техникчийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэл.
- 1.4 Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулга, Зэвсэгт хүчний Жанжин штабын Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн тоглолтын хувцас, хэрэглэл.
- 1.5 Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн сонсогчийн хувцас, хэрэглэл.
- 1.6 Тусгай үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчийн тусгай зориулалтын хамгаалах хувцас, хэрэглэл.
- 1.7 Цэргийн эмнэлгийн байгууллагад ажилладаг эмч, сувилагч, ажилтан, өвчтөний хувцас, хэрэглэл.
- 1.8 Харуулчийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэл.
- 1.9 Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн дотуур хувцас, ахуйн хэрэглэл.
- 1.10 Цэргийн анги, салбарын үйлчилгээний албан тушаалд ажилладаг алба хаагчийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэл.
- 1.11 Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн ажлын хувцас, хэрэглэл.
- 1.12 Цэргийн алба хаагчийн тоног төхөөрөмж, эд хогшил.

Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний тусгай зориулалтын хувцас хэрэглэлийн загвар, нормыг Батлан хамгаалахын сайдын тушаалаар батлуулахаар төлөвлөн ажиллаж байна.

- 1.1 Цэргийн алба хаагчийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэл.

1. Хамгаалалтын дуулга

Баллистик бүтэцтэй "level III A" дуулга нь бүх төрлийн гар бууны сум нэвтрүүлэхгүй, олон давхаргат арамид нийлмэл материалаар хийгдсэн бөгөөд байлдааны нэмэлт багаж хэрэглэлээр (шөнийн харааны хэрэгсэл, буудлагын чихэвч, гар чийдэн гэх мэт) тоноглох боломжтой зориулалтын замтай байна. Энэхүү дуулга нь зөвхөн гар бууны сумнаас хамгаалахаас гадна цохилт, доргилтоос хамгаалах зориулалттай.

2. Хамгаалалтын нүдний шил I

Нүдний шил нь хээрийн нөхцөлд цэргийн алба хаагчийн нүдэнд ус, шороо, тоос, цас орохоос сэргийлэх ба цаг агаарын нөхцөлд тохируулан өнгийг сольж зүүх

боломжтой (эсвэл өнгө хувирдаг хамелеон шил), резинэн чангалууртай, металл ороогүй бүтэцтэй байна. Тухайн шил нь 99 хувийн хэт ягаан туяаны хамгаалалттай, гялбаа, зурагдалт, цанталтын эсрэг хамгаалалттай.

3. Хамгаалалтын нүдний шил II

Нүдний шил нь буудлага хийх үед сумны тэсрэлтээс үүссэн хий, дарийн үлдэгдэл нүдрүү орохоос хамгаалахаас гадна салхитай, шороон шуургатай үед харах нөхцөлийг сайжруулна. (шилний хамгаалалтын бүрхүүлийн цайртай) байлдааны ажиллагаанаас хамаараад нэмэлтээр олгогдох шил юм.

4. Хантааз

Хантааз /ялтастай/ дангаараа "Level IIIA" нь бүх төрлийн гар бууны сум нэвтрүүлэхгүй, буудлага, хээрийн дадлага сургууль, бэлэн байдлын зэргүүдэд шилжих үед захирагч даргын шийдвэрээр өмсөж хэрэглэнэ. Мөн нэмэлт хэрэглэлээр тоноглож болох зангуу болон ременьтэй, тайлах, өмсөхөд хялбар, хөдөлгөөн хязгаарлахгүй шийдэлтэй хийгдсэн байна. Хантаазны дотор хэсэг нь хүний биед тухтай байдлыг хангах зорилгоор зөөлөвчтэй, амьсгалдаг материалаар хийгдсэн. Ялтас "Level IV" түвшний автомат бууны сумнаас хамгаалах зориулалттай. Тактикийн олон зориулалтын бүс бэхлэгч дэмжигчтэй, мөрний хамгаалалтын зөөлөвчтэй. Ойрын зайн байлдааны ажиллагаа болон бусад ажиллагаанд зориулагдсан олон үйлдэлт хуяглагдсан байна.

5. Агсамж

Агсамж нь "Level III" ангиллын хамгаалалттай буюу бүх төрлийн гар буу, тэсрэлтийн хэлтэрхийнээс хамгаалах чадамжтай. Тактикийн олон зориулалтын бүс бэхлэгч дэмжигчтэй, мөрний хамгаалалтын зөөлөвчтэй. Ойрын зайн байлдааны ажиллагаа болон бусад ажиллагаанд зориулагдсан олон үйлдэлт хуяглагдсан байна.

6. Өвдгөвч, тохойвч

Хурдан чангалах, суллах түгжээтэй ба үүрэг гүйцэтгэх үед хөдөлгөөнд саад болохгүй, биед сууж өгдөг онцлогтой байна.

Бор шар /дигитал/ өнгийн хатуулгатай, хатуулгын ард хээрийн хувцасны өнгө дагуу өнгийн материалаар бүрсэн зориулалтын зөөлөвчтэй, агаар нэвтрүүлдэг, торон даавуун дотор бүтэцтэй байна.

7. Тактикийн бээлий

Сургалт бэлтгэлийн үед гар урах, бэртэж гэмтэхээс хамгаалах бөгөөд зөөлөн материалаар хийгдсэн, хүний гарт сууж өгдөг ба буудлага хийх (байлдааны зэвсэглэл техниктэй харьцах) үед гарт тээр болохгүй, хурууны хөдөлгөөн хорихгүй, ус нэвтэрдэггүй, халуунд тэсвэртэй, зүсэлт элэгдэлтэд тэсвэртэй бат бөх чанартай байна.

8. Аранз

Цэргийн зориулалттай үндсэн ба туслах материалууд нь чанарын шаардлага хангасан бат бөх байна. Бор шаргал /дигитал/ өнгийн Cordura зориулалтын

материалтай. Ремень оруулга бүхий давхар бэхлэгчүүдтэй. Ус, чийгийн хамгаалалттай, мөрөвч болон нурууны арын хэсэгт ачаалал тэнцвэржүүлэх зориулалтын зөөлөвчтэй, сайн чанарын түгжээ, цахилгаантай. Хэмжээ: урт нь 40 см-ээс багагүй, өргөн 20 см-ээс багагүй, өндөр нь 85 см. Цүнхний оёдол давхар оёгдсон, 2-3 том тасалгаатай, 70 кг-ын даацтай 70-80 литрийн багтаамжтай байна.

9. Тактикийн 72 цагийн аранз

Цэргийн зориулалттай үндсэн ба туслах материалууд нь чанарын шаардлага хангасан бат бөх байна. Бор шаргал /дигитал/ өнгийн Cordura зориулалтын материалтай. Ремень оруулга бүхий давхар бэхлэгчүүдтэй. Ус, чийгийн хамгаалалттай, мөрөвч болон нурууны арын хэсэгт ачаалал тэнцвэржүүлэх зориулалтын зөөлөвчтэй, сайн чанарын түгжээ, цахилгаантай. 25x45x20 см багагүй хэмжээтэй. ЦАХ-ийг 72 цагийн турш тактикийн даалгавар, алсын зайн маршийн үед байлдааны болон тусгай үүрэг гүйцэтгэх үед чухал хэрэгслийг ачаалахад зориулагдсан.

10. Цүнх /офицер/

Авсаархан, хөнгөн, бат бөх, бүх төрлийн гарын авлага, дэвтрийг хийх боломжтойгоос гадна нэмэлтээр жижиг хэмжээтэй цүнхийг гадна талд суурилуулж, түүнд амьд гарах хэрэгсэл, холбооны хэрэгсэл, жагсаал удирдах дохионы дэрцаг, хувийн эд хэрэгслийг суурилуулж ашиглах боломжтой. Хэмжээ 40*25*6 см багагүй.

11. Тактикийн бүс I

Кабур (бууны гэр), магазины үүр, жижиг хэрэгслийн цүнх, эмнэлгийн анхан шатны тусламжийн цүнх зэрэг олон төрлийн хүнд хэрэгсэл зүүхэд зориулагдсан бөгөөд өмдний тэлээний гадуур зүүх учир зүүж тайлахад хялбар, сургалт, дадлага, буудлага хийх үед болон тусгай ажиллагааны үед хэрэглэнэ.

12. Тактикийн бүс II

Кабур (бууны гэр), магазины үүр, жижиг хэрэгслийн цүнх, эмнэлгийн анхан шатны тусламжийн цүнх зэрэг олон төрлийн хүнд хэрэгсэл зүүхэд зориулагдсан бөгөөд өмдний тэлээний гадуур зүүх учир зүүж тайлахад хялбар, сургалт, дадлага, буудлага хийх үед болон тусгай ажиллагааны үед хэрэглэхэд хялбар. Холын зайн явган маршид цэргийн алба хаагчийн биеийн тааз хэсэгт суурь болж өгдөг, бүсэлхий хэсэгт зөөлөвчтэй.

13. Борооны цув

Борооны цув нь бүх төрлийн хувцас дээр өмсөх боломжтой. Юүдэнтэй загвартай, даавуун дотортой тул дулааныг гадагшлуулахгүй, чийг татахгүй, ус нэвтрүүлдэггүй, олон давхар мембран материалтай байна.

14. Биеийн тамирын хувцас

Зүүн энгэрт төрийн далбаа 40x80мм-ийн харьцаатай зангуун наалттай, цээж хэсэгт цагаан оруулга, саарал өнгийн хавчуургатай, нуруу хэсэгт "МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН", олон улсын арга хэмжээ, гадаад улсад явагдах сургалт, энхийг дэмжих ажиллагаанд "MONGOLIAN ARMED FORCES" гэсэн өнгө дагуу наамал

бичиглэлтэй, ханцуй манжеттай, хормой болон өмдний шуумаг хэсэг татуурга бүхий чангалууртай, цээж болон өмдөнд цахилгаантай халаастай байна.

15. Биеийн тамирын шорт, футболк

Дугуй цагаан захтай. Зүүн энгэрт төрийн далбаа 40x80мм-ийн харьцаатай, ар нуруун хэсэгт МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН", олон улсын арга хэмжээ, гадаад улсад явагдах сургалт, энхийг дэмжих ажиллагаанд "MONGOLIAN ARMED FORCES" гэсэн цэнхэр өнгийн наамал бичиглэлтэй ташааны оёдолдоо саарал өнгийн хавчуургатай, шортны дээд тал нь резинтэй, даавуун чангалууртай байх ба "MAF" гэсэн цагаан өнгийн наалтан бичиг зүүн гуяны урд талын гадна талд байна.

16. Даавуун болон ноосон оймс

Даавуун оймс – 100 хувийн хөвөн даавуун, ноосон оймс - 70 хувийн ноос, 30 хувийн хөвөн даавуун бүтэцтэй. Хар, хар-хөх өнгөтэй "Янмал", "Тод" брэндийн ноосон оймстой дүйцэхүйц өргөн хэрэглээний, оймсны түрий нь 20-23 см багагүй байна. Эрүүл ахуйн шаардлага хангасан будаг гардаггүй, хүний биед харшил өгөх гаж нөлөөгүй байна.

17. Биеийн тамирын гутал

Олон улсын чанарын шаардлага хангасан цагаан, саарал өнгөтэй пүүз байна. Гутлын ул сайн чанарын халтирдаггүй үйсэн материалтай. Чийг шингээх гадагшлуулах чадвар сайтай, өнгө үзэмж сайтай пүүз байна.

1.2 Тусгай хүчний цэргийн алба хаагчийн тактикийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэл.

1. Зуны саравчтай малгай

Толгойны хэлбэрт сууж өгөх ба өмсөхөд эвтэйхэн, авч явахад хялбар, буудлагын чихэвч зүүхэд тохиромжтой, 67 хувийн полиэстер, 33 хувийн хөвөн даавуу бөгөөд толгойг хөлрүүлэхгүй, агаарын солилцоо сайн. Малгайны урд хэсэгт 40x80мм-ийн харьцаатай зангуун наалттай (хар, саарал өнгийн) төрийн далбаатай.

2. Тактикийн хүрэм

Сэрүүний улиралд өмсөх зориулалттай бөгөөд үндсэн материал нь полиэстер болон ноосны хольцтой, энгэрийн болон нуруу хэсэг нь ус нэвтрүүлэхгүй нелон материалтай. Суганы хэсгээс доош агаар нэвтрүүлэх зориулалттай полиэстер торон материалтай. Хүрмийн ханцуйн манжетик нь сунаж агцдаг /шоллер динамик буюу 92 хувийн полиамид, 8 хувийн эластан/ материалтай бөгөөд том овортой цаг зүүсэн үед ч өмсөж тайлахад саад болохгүй

3. Хантаазны цамц

Хээрийн цахилгаантай цамцны үндсэн материал нь 67 хувийн полиэстер, 33 хувийн хөвөн даавуу бөгөөд цамцны энгэр, нурууны хэсэгт сунадаг (шоллер динамик буюу 92 хувийн полиамид, 8 хувийн эластан) материалтай тул хүний биеийн галбираар сууж өгдөг давуу талтай. Суганы дотор хэсгээр агаар чөлөөтэй нэвтрүүлэх полиэстер торлог материалтай. Мөрний дотор талд зөөлөвч хийх

зориулалттай торлог халаастай, тохойн хэсэгт зөөлөн эдлэл бүхий нимгэн оруулгатай, оруулгын дээд хэсэгт тохойвч хийх зориулалттай халаастай. Баруун, зүүн мөрний залгаа оёдлоос доош ханцуйн дээр босоо цахилгаантай халаастай бөгөөд ялгах тэмдэг тогтоох зангуутай, зангууны гол хэсэгт үзэг хийх зориулалттай нүхтэй. Хээрийн цахилгаантай цамцны хормойн хоёр хажуу хэсэгт байрлах зөөлөн эдлэл бүхий нимгэн оруулга нь өмдний дотуур орох бөгөөд бүсэнд гар буу болон бусад тоног хэрэглэл зүүсэн үед хүний ташааны яс холгуулахгүй байх зориулалттай.

4. Тактикийн өмд

Үндсэн материал нь 67 хувийн полиэстер, 33 хувийн хөвөн даавуу бөгөөд өмдний арын босоо оруулгаас доош гуяны болон хоёр хажуу талд сунадаг (шоллер динамик буюу 92 хувийн полиамид, 8 хувийн эластан) материалтай тул чөлөөтэй хөдлөх боломжийг нэмэгдүүлнэ. Мөн өмдний хоёр хажуу талд зангуутай дотуур бүстэй тул сунаж агших материалын суналтыг өөрийн биед тааруулж хязгаарлах боломжтой, нурууны хэсэгт зөөлөн эдлэл бүхий агаар нэвтрүүлэх оруулгатай, өвдөгний хэсэгт зөөлөн эдлэл бүхий нимгэн оруулгатай, оруулгын дээд хэсэгт өвдгөвч хийх зориулалттай цахилгаантай халаас, доод хэсэгт өвдгөвчний хатуулга хийх зангуутай халаастай. Хажуу талдаа дайз, хутга, гар чийдэн хийх зориулалттай давхар босоо халаастай. Мөн урд хэсэгтээ босоо цахилгаантай, агаар нэвтрүүлэх зориулалттай торлог бөгөөд дотор талдаа давхар босоо цахилгаантай дотуур халаастай. Хажуугийн халаасны дотор талд өмдөнд өвдгөвч хийсэн үед өмдний өвдгийг доош унжихаас сэргийлж дээш татаж тааруулах зориулалттай 5 см урттай товчилдог татуургатай. хүний биеийн онцлогийн хэмжээнд тохируулан размер тохируулагчтай хөлийн урт богиноос шалтгаална.

5. Дотуур цамц, өмд

Дотуур өмд цамц нь агаар сэлгэлт сайн, хөлс гадагшлуулдаг, биеийн дулааныг гадагшлуулдаггүй амьсгалдаг материалтай.

6. Тактикийн маск

ЦАХ-ыг бүх төрлийн цаг агаарын нөхцөлд амьсгалыг чөлөөтэй авахад тохиромжтой, амьсгалдаг, бактери үржихгүй, сунаж, агшдаг материалтай.

7. Тактикийн өвлийн малгай

Биеийн дулааныг хадгалан амьсгалдаг өвлийн малгай, 33 хувийн полиэстер, 67 хувийн хөвөн даавуун материалтай бөгөөд толгойг хөлрүүлэхгүй, агаарын солилцоо сайн.

8. Тактикийн өвлийн хүрэм

Үндсэн материал нь 100 хувийн нелон материалтай сөдөн доторлогоотой тул чөлөөтэй хөдлөх боломжийг нэмэгдүүлнэ, удаан хугацаагаар алхах, бэлтгэл сургуулилт хийх үед хүний биед эвтэйхэн байна. Мөн хөдөлгөөнийг хорихгүй өвлийн -40 хэм болон сэрүүний улиралд биеийн дулааныг алдуулахгүй үүрэг гүйцэтгэх боломжийг олгодог.

9. Тактикийн өвлийн бээлий

Тактикийн өвлийн бээлий нь дулаан барихаас гадна буудлага хийхэд зориулагдсан хуруутай болон хуруугүй бээлий болох зориулалттай. Арьсан материалтай.

10. Зуны гутал

Буудлага хийхэд болон удаан хугацаагаар зогсоход хөлд эвтэйхэн, хөлийн тэнцвэр барьж, биеийн дулааныг хадгална, -15-+30 хэмийн зориулалттай, тактикийн зориулалттай тул үдээс түгжигчтэй.

11. Хэт хүйтний гутал

Хэт хүйтний гутал нь дулааныг хадгалж чийгтэхгүй, дотор талдаа нэмэлт оймстой байх ба гадаргуу тал дээр ус нэвтрүүлэхгүй, хад чулууны хамгаалалттай байна.

1.3 Нисгэгч, нисэхийн инженер, техникчийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэл.

1. Майхан малгай

Малгай нь 65 хувийн хөвөн даавуу 35 хувийн синтетик холиотой. Цайвар ногоон өнгөтэй майхан малгайг нисгэгч нислэг үйлдэх үед, хөх өнгийн майхан малгайг нисэхийн инженер, техникч нислэгийн аюулгүй ажиллагааг хангах үед өмсөж хэрэглэнэ.

2. Ноосон малгай

Нэхмэл 65 хувийн хөвөн даавуу 35 хувийн синтетик холиотой хар ноосон малгай өмсөж хэрэглэнэ.

3. Зуны хүрэм, өмд

Нисгэгч-цайвар ногоон, инженер, техникч -хар хөх өнгөтэй. 65 хувийн хөвөн даавуу 35 хувийн синтетик холиотой, биед эвтэйхэн, галд тэсвэртэй материалтай. Зуны улиралд нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй ажиллагааг хангах үед өмсөж хэрэглэнэ.

4. Савхин хүрэм (нисгэгч)

Савхин хүрэм нь хавар, намрын улиралд нислэг үйлдэх үед цаг агаарын нөхцөлд тохируулан өмсөж хэрэглэнэ.

5. Зулхай дотортой хүрэм

Инженер-техникчид хавар, намрын улиралд нислэгийн аюулгүй ажиллагааг хангах үед өмсөж хэрэглэнэ.

6. Комбинезон

Комбинезон нь 97 хувийн хөвөн даавуу 3 хувийн спандекс. Сэрүүний улиралд нислэг үйлдэх үед нисгэгч, инженер-техникчийн бүрэлдэхүүн өмсөж хэрэглэнэ.

7. Хэт өндөр нислэгийн бүрэн томоглолтой дуулга

Нисгэгчийн толгойг урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдал болон хөөрөх үед үзүүлэх нөлөөллөөс хамгаалах зориулалттай. Сөхөгддөг нарны халхавч нь нисгэгчийг хэт ягаан туяанаас хамгаална. Атираат агаар дамжуулагчаар дамжуулан хүчилтөрөгчийн хангамжийн систем нь далайн түвшнээс дээш 15000-20000 метрийн өндөрт цусан дахь хүчилтөрөгчийг хадгалж байдаг.

8. Гэнэтийн агаарын даралтаас хамгаалах хувцас

ППК-3 (Противо Перегрузочный Костюм)– Өндөр даралттай маневрын үед нисгэгчийн цусны эргэлтийг тогтмол барьж байх зориулалттай, хүний биед тааруулан хийлэгддэг.

9. Хэт өндрийн нислэгийн комбинезон

ВКК-6М (Высотный Компенсирующий Костюм)– нисгэгчийг гэнэтийн агаарын даралтын өөрчлөлтөөс хамгаалах, хэт өндөрт биеийн даралтыг тогтвортой барих, цусны эргэлтийг тогтворжуулах зориулалттай, хүний биед тааруулан хийлэгддэг. -50,+50С, 12-55 км өндөрт үүрэг гүйцэтгэхэд өмсөж хэрэглэдэг. ВКК-6М, ППК-3 хувцаснуудыг нисгэгчдэд өндрийг тааруулан олгодог.

10. Өвлийн тинсулейт дотортой хүрэм, комбинезон

Хар хөх өнгөтэй, 65 хувийн хөвөн даавуу 35 хувийн синтетик холиотой, биед эвтэйхэн, галд тэсвэртэй. Өвлийн улиралд нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй ажиллагааг хангах үед нисгэгч, инженер-техникчид өмсөж хэрэглэнэ.

11. Футболк

Футболк нь 100 хувийн хөвөн даавуун материалтай цагаан болон хөх өнгөтэй. Дулааны улиралд нисгэгчид цагаан, инженер-техникчид хөх өнгөтэйг нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй ажиллагааг хангах үед өмсөж хэрэглэнэ.

12. Ноосон цамц

Флис материалтай (хөнгөн, биед эвтэйхэн, хөдөлгөөн хязгаарлахгүй, биеийн дулааныг хадгалдаг, ямар ч улиралд өмсөх боломжтой, агаар сайн нэвтрүүлдэг, зөөлөн) хөх өнгийн ноосон цамц нь нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй байдал хангах үед өмсөж хэрэглэнэ.

13. Зуны гутал

Стандартын шаардлага хангасан сайн чанарын арьсан материалтай гутал. Нислэг үйлдэх, нислэгийн аюулгүй ажиллагааг хангах үед өмсөж хэрэглэнэ.

14. Өвлийн гутал

Арьсан материалтай, нэхий дотортой өвлийн хагас түрийтэй гутлыг нислэг үйлдэх үед нисгэгчид, урт түрийтэй гутлыг нислэгийн аюулгүй ажиллагааг хангах үед нисэхийн инженер, техникчид тус тус өмсөж хэрэглэнэ.

1.4 Цэргийн дуу бүжгийн эрдмийн чуулга, Зэвсэгт хүчний Жанжин штабын
Үлгэр жишээ үлээвэр найрал хөгжмийн тоглолтын хувцас, хэрэглэл

1. Удирдаач, гоцлол дуучдын тоглолтын китель, өмд, юбка

60 хувийн ноос, 37+3 (полистер+спандекс) материалтай номин ногоон өнгөтэй китель, өмд, юбкаг ЦДБЭЧ-ын удирдаач, гоцлол дуучид тоглолтын үйл ажиллагаанд өмсөж хэрэглэнэ.

2. Гоцлол дуучдын тоглолтын китель, өмд, юбка

60 хувийн ноос, 37+3 (полистер+спандекс) материалтай шаргал өнгөтэй китель, өмд, юбкаг ЦДБЭЧ-ын гоцлол дуучид тоглолтын үйл ажиллагаанд өмсөж хэрэглэнэ.

3. Тоглолтын саравчтай малгай

60 хувийн ноос, 37+3 (полистер+спандекс) материалтай тоглолтын саравчтай малгайнд эвэр угалз хээ, саравчинд тариан түрүү хээг тус тус хатгасан. Тоглолтын үед өмсөж хэрэглэнэ.

4. Найрал дуучид, хөгжимчид, бүжигчдийн китель, өмд, юбка

60 хувийн ноос, 37+3 (полистер+спандекс) материалтай ногоон китель, өмд, юбкаг ЦДБЭЧ-ын найрал дуучид, хөгжимчид, бүжигчид тоглолтын үйл ажиллагаанд өмсөж хэрэглэнэ.

5. Төрийн болон цэргийн ёслолын тоглолтын саравчтай малгай

60 хувийн ноос, 37+3 (полистер+спандекс) материалтай саарал өнгийн саравчтай малгай. Төрийн болон цэргийн ёслолын тоглолтын саравчтай малгайнд эвэр угалз хээ, саравчинд тариан түрүү хээг тус тус хатгасан. Тоглолтын үед өмсөж хэрэглэнэ.

6. Төрийн болон цэргийн ёслолын тоглолтын китель, өмд

60 хувийн ноос, 37+3 (полистер+спандекс) материалтай саарал китель, хар хөх өмдийг ЗХЖШ-ын ҮЖҮНХ-ийн уран бүтээлчид төрийн болон цэргийн ёслолын тоглолтын үйл ажиллагаанд өмсөж хэрэглэнэ.

7. Тоглолтын китель, өмд

60 хувийн ноос, 37+3 (полистер+спандекс) материалтай ногоон китель, өмдийг ЗХЖШ-ын ҮЖҮНХ-ийн уран бүтээлчид тоглолтын үйл ажиллагаанд өмсөж хэрэглэнэ.

Дээрх тоглолтын хувцасны шинж чанар нь:

- Малгайнд эвэр угалз хээ, малгайны саравчинд тариан түрүү урласан.
- Зах болон ханцуйнд өлзий хээг эвэр угалз хээтэй хослуулан урласан.
- Гарын ханцуйнд мөн тариан түрүү хээг урласан.

1.5 Цэргийн сургуулийн сонсогчийн хувцас, хэрэглэл

Үндэсний батлан хамгаалах их сургуулийн Цэргийн нэгдсэн сургуулийн сонсогч нар нь 4 жилийн хугацаанд 1 удаа сэрүүний ба дулааны улирлын хээрийн болон албаны хувцсаар хангагдана. Хээрийн хувцасны өнгө загвар нь Монгол Улсын ерөнхийлөгчийн 2024 оны 141 дүгээр зарлигийн дагуу байна.

1. Хээрийн хувцас: Хээрийн хувцсыг сонсогч нар нь өдөр тутмын үйл ажиллагаа, хээрийн сургалт, дадлага, хээрийн ба дадлагын хичээлийн үед, байлдааны ажиллагаа, буудлага, хоногийн харуул манааны үед өмсөж хэрэглэнэ.

1.1 Дулааны улирлын хээрийн хувцас

Хээрийн саравчтай малгай: Сонсогч нар хээрийн хувцас өмсөх бүх тохиолдолд хэрэглэнэ. Хээрийн малгайны үзүүрийг хөмсөгний доод түвшинд дарж өмсөнө.

Хээрийн зуны китель, өмд: Сонсогч нар бүх тохиолдолд резинэн татуурга бүхий өмдний шуумгийг гутлын түрүүний гадуур тавьж өмсөх ба гутлын түрийний 2/3 нь ил байхаар тохируулна. Хээрийн сургуулилт болон дадлагын үед кителийн захыг босгож хэрэглэж болно. Хээрийн зуны кителийг энгэрийн нэр, цусны бүлэг, дамжааны ялгахын хамт хэрэглэнэ.

Хээрийн футболк: Хээрийн хувцас өмсөх бүх тохиолдолд хэрэглэнэ.

Хагас түрийтэй зуны хар гутал: Хээрийн хувцас хэрэглэх бүх тохиолдолд хэрэглэнэ. Хагас түрийтэй хар гутал нь элдэв хээгүй цулгүй байна.

Даавуун оймс: Хар өнгийн шилбэ хүрсэн урттай байх ба бүх тохиолдолд хэрэглэнэ.

1.2 Сэрүүний улирлын хээрийн хувцас

Өвлийн ноосон малгай: Хээрийн хувцас өмссөн бүх тохиолдолд хэрэглэнэ. Малгай урд хэсэгт үндэсний батлан хамгаалах их сургуулийн логотой байна.

Хээрийн өвлийн хүрэм, өмд: Сонсогч нар бүх тохиолдолд резинэн татуурга бүхий өмдний шуумгийг гутлын түрүүний гадуур тавьж өмсөх ба гутлын түрийний 2/3 нь ил байхаар тохируулна. Хээрийн өвлийн хүрмийг энгэрийн нэр, цусны бүлэг, дамжааны ялгахын хамт хэрэглэнэ.

Ноосон цамц: Сэрүүний улиралд хэрэглэнэ.

Хагас түрийтэй өвлийн хар гутал: Хээрийн хувцас хэрэглэх бүх тохиолдолд хэрэглэнэ. Хагас түрийтэй хар гутал нь элдэв хээгүй цулгүй байна.

Ноосон оймс: Сэрүүний улиралд хэрэглэнэ.

Савхин бээлий: Сонсогч нар хар өнгийн 5 хурууны бээлий хэрэглэнэ.

2. Албаны хувцас: Албаны хувцсыг сургууль жагсах болон танхимын хичээл сургуулилтын үед хэрэглэнэ.

2.1 Дулааны улирлын хээрийн хувцас

Албаны саравчтай малгай: Албаны хувцас өмссөн бүх тохиолдолд хэрэглэнэ. Малгайн саравчны үзүүрийг хөмсөгний доод түвшинд дарж өмсөнө.

Албаны китель, өмд: Танхимын сургалтын үед хэрэглэнэ. Албаны хувцас өмссөн үед албаны хувцасны мөрдэс, төмөр таних тэмдэг, нэрийн тэмдэг, анги ялгах тэмдэг болон хатгамал оны ялгааг хэрэглэнэ.

Албаны цамц: Албаны хувцас хэрэглэх бүх тохиолдолд хэрэглэнэ. Албаны цамцыг зангианы хамт хэрэглэх ба цамцны дээд товчийг товчилсон байх шаардлагатай.

Зуны гутал: Албаны хувцас өмссөн бүх тохиолдолд хэрэглэнэ. Зуны ботинк нь элдэв хээгүй цулгүй байна.

Даавуун оймс: Хар өнгийн шилбэ хүрсэн урттай байх ба бүх тохиолдолд хэрэглэнэ.

2.2 Сэрүүний улирлын албаны хувцас

Өвлийн цегейк малгай: Сэрүүний улиралд өмсөнө. Өвлийн малгайны цохны доод ирмэг нь хөмсөгнөөс 1 см дээр байрлах ба өвлийн малгайг буулгаж хэрэглэх тохиолдолд бүчийг эрүүн доогуур эвсэл малгайн ард бүчилнэ.

Ноосон пальто: Сэрүүний улиралд өмсөнө. Албаны пальтог хатуу сонсогч мөрдэс, дамжааны ялгахын хамт хэрэглэнэ.

Өвлийн гутал: Албаны хувцас өмссөн бүх тохиолдолд хэрэглэнэ. Өвлийн ботинк нь элдэв хээгүй цулгүй байна

Ноосон оймс: Сэрүүний улиралд хэрэглэнэ. Ноосон оймс нь хар өнгийн байна.

1.6 Тусгай үүрэг гүйцэтгэх цэргийн алба хаагчийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэл

1. Ус үл нэвтрэх хувцас

Хүрэм, өмд нь ус, чийгийг нэвтрүүлдэггүй, биед эвтэйхэн: 65 хувийн полиэфир, 35 хувийн хөвөнгийн холимгоор хийгдсэн бөгөөд энэ нь полиэстериин элэгдэлд тэсвэртэй байдлыг хөвөнгийн амьсгалах чадвартай хослуулж, хувцасны бат бөх чанарыг хангаж, олон цагаар гадаа ажиллахад тав тухтай байдлыг хангана.

Хүрэм болон өмд нь цахилгаан товчтой бөгөөд энэ нь хурдан өмсөж, тайлахад хялбар төдийгүй эд зүйлсийг найдвартай хадгалах багтаамжтай, шаардлагатай эд зүйлсийг авч явахад хялбар болгох үүднээс олон цахилгаан товчтой халааснуудаар тоноглогдсон.

2. Усны гутал

Хөлийн анатомийн бүтцэд нийцсэн хэвтэй, гутлын гадар нь резин, полимер эдлэлээр хийгдсэн байх ба дотор хэсэг нь даавуун доторлогоотой, бат бөх хийцтэй байх. Ул, өсгий, урд хоншоор, шагай, тавхайн хэсэгт нэмэлт хамгаалалттай, элэгдэлд тэсвэртэй материалаар хийгдсэн байна. Гутлын гуяны тойрог болон гуяны

нээлхий загвар нь гуяны гутлыг өмсөхөд илүү тохиромжтой болгодог. Өтгөрүүлсэн резин бүхий гулддаггүй ул нь цэргийг усанд ажиллахад аюулгүй байдлыг хангана.

3. Хөвөх хантааз

Полиэтилен хөөс, хөвөх материалтай аврах хантааз нь 110-130 кг хүртэлх жинг усны гадаргууд хөвүүлэх зориулалттай бөгөөд цэргийг усанд ажиллахад аюулгүй байдлыг хангана. Хөвөх хантааз нь гэрэл ойлгогчтой (фосфор), Мөрний хэсэг нь тод гэрэлтдэг оосроор тоноглогдсон тул аврах багийнхан усанд амархан илрүүлэх боломжтой. Мөн тохируулах боломжтой бэлхүүс загвар нь олон хүнд эвтэйхэн өмсөх боломжийг олгодог. Жин: 600 гр, урт 55 см.

4. Гар чийдэн (усны хамгаалалттай)

Дэвшилтэт LED чиптэй, 950000 люмен гаралттай, 120 квадрат метр талбайтай гэрэлтүүлнэ. (Люмен нь олон улсын нэгжийн СИ систем дэх гэрлийн урсгалыг хэмжих уламжлагдсан нэгж юм.) Гар чийдэн нь 12 цаг хүртэл тасралтгүй ажиллах, USB кабелиар цэнэглэх боломжтой. 5 гэрэлтүүлгийн горимтой. Гар чийдэнгийн толгойг сунгаж, фокусыг тохируулах, холын зайн ажиглалт, өргөн хүрээний гэрэлтүүлгийг чөлөөтэй сонгох боломжтой. Гар чийдэн нь цаг агаарын ямар ч нөхцөлд ажиллах боломжтой.

5. Хамгаалалтын бээлий

Хамгаалалтын ажлын бээлий, цооролт, зүсэлтэд тэсвэртэй, ган голтой сүлжмэл доторлогоотой. Усны хамгаалалттай, чийг нэвтрүүлэхгүй, гарыг хуурай байлгана.

6. Нүдний шил (усны хамгаалалттай)

Нүдийг гадны биет, хурц гэрлээс хамгаалах зориулалттай байна. Тусгай зориулалтын шил нь цанталтын эсрэг линзтэй, уян оосортой, уртыг хялбархан тохируулах боломжтой, өмсөж тайлахад хялбар байна.

7. Аврах олс

Аврах олс нь олон үе давхарга бүхий сүлжмэл утастай, сүлжмэлийн гол хэсэгт тросстой байна. Гадна талын бүрээс нь үрэлт, зулгаралтад тэсвэртэй, нарны хэт ягаан туяанаас хамгаалах бүтэц бүхий нэхмэл материал /Кернмантел/-тай. Аврах олс нь 14мм голчтой, урт нь 30, 50, 100м болон 200м урт байна.

8. Усны тагнуулын багаж

Төрөл бүрийн усан сан, голын мониторингийн хэрэгцээнд тохируулан 100м-ээс 500м хүртэлх усны гүнд хэмжилтийг хийнэ. Хэмжилтийг $\pm 0.5\%$ -иас дээш нарийвчлалтай заана.

9. Аврах цагариг

Тогтоол болон урсгал усанд живүүлэхгүй хөвөх зориулалттай, полистер, PVC материалтай. 20-25 метр урт олстой, 110-130 кг хүртэлх даацтай.

10. Комбинезон

Өндөр бат бэх полиэтилен утаснаас бүтсэн, хүний биеийг химийн бодисоос хамгаалах, тусгаарлах материалтай байна. Цагаан өнгөтэй ба тусгай үүрэг гүйцэтгэх үед өмсөж хэрэглэнэ.

11. Хошуувч

Химийн бодис, утаа, угаар болон хорт хийн бүтээгдэхүүнээс амьсгалын замын эрхтнийг хамгаалах ба тусгай үүрэг гүйцэтгэх үед өмсөж хэрэглэнэ.

12. Резинэн бээлий

Гарыг химийн бодисоос хамгаалах, тусгаарлах үүрэгтэй, резинэн материалтай байна. Хар өнгөтэй ба тусгай үүрэг гүйцэтгэх үед өмсөж хэрэглэнэ.

13. Усны гутал

Гутлын гадар нь резин, дотор нь сүлжмэл даавуун материалтай байх ба тусгай үүрэг гүйцэтгэх үед өмсөж хэрэглэнэ.

14. Ажлын хувцас

Ажлын нөхцөлд тохирсон загвартай, хөдөлгөөнд саад болохгүй, өмсөж тайлахад хялбар, дулаан хадгалж, агаар нэвтрүүлдэг материалтай байна.

15. Ажлын бээлий

Гарт эвтэйхэн, бат бөх, эдэлгээ даах, даавуун зөөлөн материалтай, 45 гр-аас багагүй утсаар шигүү нэхсэн, цагаан өнгөтэй, сайн чанарын, хагас будагтай 5 хурууны бээлий байна.

16. Галд тэсвэртэй байлдааны хувцас

Хар хөх өнгөтэй, шаргал бор өнгийн цацруулагчтай сүүлийн үеийн стандартын шаардлага хангана. Барилга байгууламжийн гал түймэр унтраах болон аврах ажиллагааг гүйцэтгэхэд гал түймрийн шаталтаас гал сөнөөгчийг хамгаалах хувцас юм

17. Брезентэн бээлий

Бээлий нь сарвууны урт, бүслүүрийн хэмжээнээс хамаарч 0-ээс 3 хүртэл өмсгөл хэмжээгээр үйлдвэрлэгдсэн байна. Хүчин төгөлдөр батлагдсан стандартын шаардлага хангасан байна. Гал түймэр унтраах, аврах ажиллагаа явуулах үед орчны хөнөөлт хүчин зүйлс буюу өндөр температур, халуун гадаргуутай хүрэлцэх механик үйлчлэл, идэвхт бодисуудаас хамгаалах зориулалттай, галд тэсвэртэй байлдааны хувцастай өмсөж хэрэглэнэ.

18. Галын дуулга

Шар өнгөтэй дуулганы гадна галын материал нэмэлт будаггүй, галд тэсвэртэй PC/ABS материалаар хийсэн байна. Сүүлийн үеийн стандартын шаардлага хангасан, гал түймэр унтраах, аврах ажиллагаа явуулах үед хөнөөлт хүчин зүйлсийн

механик болон өндөр температурын үйлчлэл, химийн бодис, ус, цаг агаарын тааламжгүй байдлаас хүний толгой, хүүзүү, нүүрийг хамгаалах хамгаалалттай.

19. Галын гутал

Тусгай галын гутал нь сүүлийн үеийн стандартын ерөнхий шаардлагыг хангасан. Гал түймэр унтраах, аврах ажиллагааны үед цаг агаар, ус чийг, механик болон физик химийн нөлөөллөөс хамгаалах зориулалттай байна. Физиологи-эрүүл ахуй, эргономикийн шаардлага хангасан угладаг дулаалгатай оймстой.

20. Сүх

Зэвэрдэггүй ган төмрөөр хийсэн, гараас халтирахааргүй резин иштэй байна. Барилга байгууламжийн гал түймэр унтраах болон аврах ажиллагааг гүйцэтгэхэд гал түймрийн шаталтаас үүсэх аюултай хүчин зүйлээс гал сөнөөгчийг хүн нэг бүрийн хамгаалах хэрэгсэл.

21. Амьсгалын бие даасан төхөөрөмж

Цагаан, саарал өнгөтэй амьсгалын бие даасан төхөөрөмж нь холимог хөнгөн цагаан материалаар хийгдсэн, гал сөнөөгч, аврагчдын харах болон амьсгалын эрхтнийг хорт хий, утаанаас хамгаалах амьсгалын бие даасан төхөөрөмж.

22. Галын бүс

Хар өнгийн бүс нь аюулгүйн олс, зөөллүүр бүхий аюулгүйн иж бүрдэлтэй. Металл эдлэлүүд нь зэврэлтэд тэсвэртэй материалаар хийсэн эсхүл зэврэлтээс хамгаалах түрхлэгтэй байна. Бүс нь (100 +/- 1) кг жинтэй ачааг (2,00 +/- 0,05) м өндрөөс унагах үед үүсэх динамик ачааллыг тэсвэрлэх ёстой.

1.7 Цэргийн эмнэлгийн байгууллагад ажилладаг эмч, сувилагч, ажилтан, өвчтөний хувцас, хэрэглэл.

1. Эмч малгай

Цагаан өнгийн, хөвөн даавуун материалтай, ажлын байранд тохируулан өмсөж хэрэглэнэ.

2. Мэс заслын халад

Цэнхэр өнгөтэй, хөвөн даавуун материалтай, мэс заслын үед өмсөж хэрэглэнэ.

3. Мэс заслын эмч, сувилагчийн цамц өмд

Цайвар цэнхэр өнгөтэй, хөвөн даавуун материалтай, мэс заслын үед өмсөж хэрэглэнэ.

4. Халад /эмч, сувилагч/

Цагаан өнгийн, хөвөн даавуун материалтай, ажлын байранд тохируулан өмсөж хэрэглэнэ.

5. Өвчтөний халад

Цэнхэр өнгөтэй, хөвөн даавуун материалтай, мэс заслын үед өмсөж хэрэглэнэ.

6. Өвчтөний цамц, өмд

Цэнхэр өнгөтэй, хөвөн даавуун материалтай эмнэлэгт хэвтэх үед өмсөж хэрэглэнэ.

7. Нөмрөг /эргэлтийн хүмүүст/

Цэнхэр өнгөтэй хөвөн даавуун материалтай. Өвчтөнд эргэлтээр ирэх үед өмсөж хэрэглэнэ.

8. Поло цамц

Саарал өнгийн флис материалтай поло цамц нь ажлын бус цагаар болон жижүүрт гарах үед өмсөж хэрэглэнэ.

9. Өвчтөний орны бүтээлэг

Цэнхэр өнгийн ноосон материалтай орны бүтээлгийг өвчтөний оронд хэрэглэнэ.

10. Нүүр гарын алчуур /эмч, сувилагч, асрагч/

Цагаан өнгийн 100 хувийн хөвөн даавуу материалтай, ажлын байранд хэрэглэнэ.

11. Ажлын гутал /эмч, сувилагч, асрагч/

Цагаан өнгөтэй, үйсэн /каучук/ материалтай, ус, тосонд халтирдаггүй, хоншоор хэсэгт хөлийн хурууны хамгаалалттай, ажлын байранд өмсөж хэрэглэнэ.

12. Углааш

Цагаан өнгөтэй, үйсэн /каучук/ материалтай, ажлын байранд өмсөж хэрэглэнэ.

1.8 Харуулчийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэл

1. Дах

Хар, хар саарал, хонь, ямааны арьсан материалтай, хүйтний улиралд цагийн манаач, харуулчид өмсөж хэрэглэнэ.

2. Нэхий бээлий

Цагаан, саарал өнгөтэй, хонины арьсан материалтай, хүйтний улиралд цагийн манаач, харуулчид өмсөж хэрэглэнэ.

3. Дэгтий

Хар, хар саарал, хонь, ямааны арьсан материалтай, хүйтний улиралд цагийн манаач, харуулчид өмсөж хэрэглэнэ.

4. Эсгий гутал

Бор саарал өнгөтэй, хонины ноосон материалтай, хүйтний улиралд цагийн манаач, харуулчид өмсөж хэрэглэнэ.

1.9 Цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчийн дотуур хувцас.

1. Дотуур цагаан цамц, өмд

Суналттай сайн чанарын сүүлийн үеийн даавуун материал байна. Хүний биед харшил өгөхгүй, хувцас дотуур өмсөх зориулалтын байна.

2. Майк, дотуур богино өмд

Хөвөн даавуун материалтай өргөн хэрэглээний майк, трусы байна. Трусы нь гуятай байх шаардлагатай. Хар, хар хөх өнгөтэй, майк нь хар саарал өнгөтэй байна.

3. Ноосон бээлий

Монгол Улсад мөрдөгдөж байгаа стандартын шаардлагыг баримтлах ба хар өнгийн 50 хувь полиэтилен, 50 хувь хөвөн даавуун материалтай байна. Хүйтний улиралд өмсөж хэрэглэнэ.

4. Даавуун оймс

Даавуун оймс нь 50 хувь полиэтилен, 50 хувь хөвөн даавуун материалтай, хар өнгөтэй чийг шингээх гадагшлуулах чадвар өндөр, 20-23 см-аас багагүй түрийтэй, өдөр тутам өмсөж хэрэглэнэ.

5. Ноосон оймс

Ноосон оймс нь зориулалтын зузаан, 70 хувийн ноос, 30 хувийн хөвөн даавуун бүтэцтэй байна. Хар бараан өнгөтэй "Янмал" брэндийн ноосон оймстой дүйцэхүйц өргөн хэрэглээний бараа байна. Оймсны түрий нь 20-23 см-аас багагүй урттай хүйтний улиралд өдөр тутам өмсөж хэрэглэнэ.

6. Углааш

Хөх, саарал өнгөтэй, үйсэн /каучук/ материалтай, өргөн хэрэглээний углааш байна.

1.10 Цэргийн анги, салбарын үйлчилгээний албан тушаалд ажилладаг алба хаагчийн тусгай зориулалтын хувцас, хэрэглэл үйлчилгээний бүрэлдэхүүний хувцас, хэрэглэлийн материал нь:

Олон улсын стандарт шаардлага хангасан зориулалтын загвар, материалаар хийгдсэн байна. Даавууны хольц 70 хувь хөвөн даавуу, 30 хувь нейлон холиотой байна.

1. Тогооч хувцас

Зүүн ханцуйнд төрийн далбаа 40x80мм-ийн харьцаатай зангуун наалттай, баруун ханцуйд анги, байгууллагын ялгах тэмдэгтэй, нуруу хэсэгт "МОНГОЛ УЛСЫН

ЗЭВСЭГТ ХҮЧИН" бичиглэлтэй, олон улсын арга хэмжээ, гадаад улсад явагдах сургалт, энхийг дэмжих ажиллагаанд "MONGOLIAN ARMED FORCES" гэсэн улаан хүрэн өнгийн наамал бичиглэлтэй, хувцасны баруун энгэрт цагаан суурин дээр улаан хүрэн өнгөтэй нэрийн зангуун наалттай байна. Ахлах тогоочийн хувцас нь зах, ханцуй болон энгэр хэсэгт улаан өнгийн туузан оруулгатай, үндэсний болон сүүлийн үеийн загварын нэмэлт хэв шинжийг агуулсан байна.

2. Ахлах тогооч, бэлтгэгч, үйлчлэгч, үйлчилгээний бүрэлдэхүүний малгай

Олон улсын болон Монгол Улсад мөрдөгдөж буй стандартын шаардлага хангасан. Үндсэн ба туслах материалууд нь цагаан, улаан, хар өнгөтэй байна.

3. Тогоочийн даавуун өмд, цамц бэлтгэгч, үйлчлэгчийн даавуун өмд, цамц

Элдэв хээ, хуар, цацаг чимэггүй, цагаан өнгөтэй, цамц хагас богино ханцуйтай, өмд бариу биш, резин татуургатай индүүдлэг авдаг байна.

4. Нөмрөг

Элдэв хээ, хуар, цацаг чимэггүй, цагаан өнгөтэй, хоолойны хэсэгт цагаан өнгийн уяатай байна.

5. Хулдаасан хормогч

Хулдаасан материалтай, урдаа халаастай, хүзүүгээр болон ардаа уяатай байна. Элдэв хээ, хуар, цацаг чимэггүй, цагаан өнгөтэй.

6. Цээживчтэй хормогч

Элдэв хээ, хуар, цацаг чимэггүй, цагаан өнгөтэй, хоолойны хэсэгт цагаан өнгийн уяатай.

7. Резинэн бээлий

Гарын арьсанд харшил үүсгэхгүй, ус, тос, химийн гаралтай бүтээгдэхүүнээс хамгаалах зориулалттай, EN388:2003,2001 EN374-1:2003 JKL, EN374-2:2003 стандарт шаардлагуудад нийцсэн, 5 хурууны бээлий байна.

8. Тогооч, үйлчлэгчийн ажлын гутал (цагаан)

Тос хүчлийн хамгаалалттай, урд хэсгийн зориулалтын хатуулга хамгаалалттай, халтирахаас сэргийлсэн ултай, цахилгаан дамжуулахгүй, чийгийг гадагшлуулах арьсан гадаргатай, хөлийн нумны зориулалтын хамгаалалттай, ус нэвтрүүлэхгүй, сүүлийн үеийн батлагдсан стандартын шаардлагад нийцсэн байна.

9. Даавуун халад

Халад нь өгзөг давсан урттай, зүүн энгэрийн дээд талд, 2 ташаандаа дөрвөлжин хэлбэрийн уутан халаастай, дан зөрлөгтэй, урт ханцуйтай байна. Зах нь дээд болон доод халаасны дээд ирмэгээр хавчуургатай, 2 см өргөн хажлагатай.

10. Гар нүүрийн алчуур

Өргөн хэрэглээний ус сайн шингээдэг гарын алчуур байна. Бор шаргал өнгөтэй, урт нь 75 см, өргөн нь 35 см-ээс ($\pm 3-5$ см) багагүй, цэвэр даавуун материалтай, өлгөх зориулалтын оосортой байна.

11. Углааш

Ердийн хэрэглээний үйсэн (каучук) шахмал хар хөх, цэнхэр өнгийн олон улсын стандарт, шаардлагыг хангасан байна.

12. Ажлын дуулга

Хөдөлмөрийн хамгаалах хэрэгсэлд тавих ерөнхий шаардлага болон олон улсын стандартын шаардлагыг хангасан байна.

13. Ажлын цамц, өмд

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартыг хангасан байна. Ажлын нөхцөлд тохирсон, хийц загвартай, хүний биеийн хөдөлгөөнд саад болохгүй, хувцас өмсөж тайлахад хялбар, дулаан хадгалах, агаар нэвтрүүлэх материалтай байна.

14. Өвлийн ажлын хүрэм, өмд

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартыг хангахуйц байна. Даавууны хольц 35 хувь хөвөн даавуу, 65 хувь нелиестер холиотой, бараан өнгөтэй байна. Хүйтний улиралд гадуур өмсөж хэрэглэнэ.

15. Ажлын бээлий

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартын шаардлага хангасан. Өдөр тутмын ажилд хэрэглэх гарт звтэйхэн, бат бөх, эдэлгээ удаан, даавуун зөөлөн материалтай, 45 гр-аас багагүй утсаар шигүү нэхсэн, цагаан өнгөтэй, сайн чанарын, хагас будагтай, 5 хурууны бээлий байна.

16. Бээлий (брэзент)

Галд тэсвэртэй, бүрэн оёдолтой, хийц сайтай, сайн чанарын, зүсэгддэггүй, урт шуутай, 5 хурууны бээлий байна

17. Ажлын гутал (зун)

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартын шаардлагыг хангасан. Үхрийн арьсан материалтай, богино түрийтэй, үдээстэй, хар эсвэл хар бараан өнгөтэй, хадаас нэвтрүүлэхгүй, цахилгаан дамжуулахгүй байна.

18. Өвлийн ажлын гутал (хөдөлмөр хамгааллын)

Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа стандартын шаардлагыг хангана. Хагас түрийтэй, үдээстэй, хар өнгөтэй байна. Зориулалтын хөлийн хурууны хамгаалалттай, халцрахаас хамгаалсан резин хоншоортой, чийгээс хамгаалагдсан зориулалтын эсгий дотортой, хадаас нэвтрүүлэхгүй, цахилгаан дамжуулахгүй байна.